



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/28

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 а, 29.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил болгон зарлах тухай” 03/06 дугаар тогтоолын 2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих” зорилтот жилийн ажлыг суманд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар байгуулсугай.
2. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

Сумын Засаг даргын 2021 оны 02 дугаар  
сарын 22 -ны өдрийн 7/28 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Б.Дэмбэрэл - Засаг даргын орлогч  
Нарийн бичгийн дарга: С.Самдан - Мал аж ахуйн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүдэд: Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Б.Доржсэмбэ - Хүнс, жижиг дунд үйлдвэр хоршооны асуудал  
хариуцсан мэргэжилтэн

Б.Ичинхоролцэвэлмаа - Мал эмнэлгийн тасгийн дарга

Т.Сундуйбаяр-Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч

Б.Бямбасүрэн-Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Ц.Нямдорж-Газрын даамал

Д.Уранчимэг-Санхүү албаны дарга

Б.Пагамдулам-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Батбаян-2 дугаар багийн Засаг дарга

Д.Галиндэв-3 дугаар багийн Засаг дарга

Д.Батбаяр-4 дүгээр багийн Засаг дарга

Ц.Лхамролом-5 дугаар багийн Засаг дарга

Ц.Амгалан-6 дугаар багийн Засаг дарга



Сумын Засаг даргын 20... оны... дугаар сарын... -ны өдрийн... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ” ЗОРИЛТОТ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021 оны 02 сарын 23

Хужирт сум

№	Ажил, арга хэмжээ	Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хугацаа	Хариуцах байгууллага	Шаардагдах хөрөнгө /төгрөг/
<b>1. “ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ” жилийн ажлыг зохион байгуулах хорооны хэрэгжүүлэх арга хэмжээ</b>					
<b>Удирдлага зохион байгуулалтын талаар</b>					
1.	Зорилтот жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	2 дугаар сард	Ажлын хэсэг	
2.	“Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулах	Сумын төсөв	1 дүгээр улиралд	Сумын ЗДТГазар	
3.	Хөдөө аж ахуйн салбарын ажилтан албан хаагчид, малчид, газар тариалан эрхлэгчид, үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх бүх төрлийн сургалтад хамруулах, туршлага судлуулах ажлыг зохион байгуулах	Аймаг, сумын төсөв	Жилдээ	ХХААГ, Сумын ХАА-н тасаг	
4.	Албан байгууллагын цайны газар болон нийтийн хоолны газруудад хуванцар шанага, сав, суулга хэрэглэхийг хориглох, айл өрхүүдэд дээрх савны хор хөнөөлийг таниулах, нөлөөллийн арга хэмжээг бүхий л төрлөөр зохион байгуулж, үр дүнг тооцох	Сумын төсөв	1-4 дүгээр улиралд	Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг	
<b>Мал аж ахуйн салбар</b>					
5.	Бог малын хээлтүүлэгчид хянан баталгаа хийж, хээлтүүлэгчийг Мал үржүүлэг, технологийн нэгжид ялган суурилж, стандарт,	Сумын төсөв	Жилдээ	Сумын Засаг дарга ХАА-н тасаг	

жишигт тэнцсэн өсвөр хээлтүүлэгчийг бойжуулан хээлтүүлэгт ашиглах	Сумын төсөв	5 сард	ХАА-н тасаг	150.000
6. Битүү аргаар хурга засах ажлыг эхлүүлж, арга зүйгээр хангах	Сумын төсөв	7 сар, 10 сард	Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг	1.000.000
7. Бод малд гүн хөлдөөсөн үрээр, бог малд шингэлсэн үрээр зохиомол хээлтүүлэг хийж биотехнологийн ололтыг нэвтрүүлэх	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө, Сум хөгжүүлэх сан	Жилдээ	Сумын Засаг дарга, ХАА-н тасаг	10.000.000
8. Газар тариалан бүхий нутаг, төв суурин газруудыг түшиглэн махны чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Төсөл, хөтөлбөрийн хөрөнгө	Жилдээ	Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг, МЭ-н тасаг	30.000.000
9. Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийг дэмжиж малчдад үйлчилгээг хүргэх	Аймаг, сумын төсөв	Жилдээ	Аймгийн Мал эмнэлгийн газар /цаашид МЭГ гэх/, сумдын Засаг дарга нар	2.550.000
10. Мал эмнэлгийн нэгдсэн системийн үйл ажиллагааг өргөжүүлж, мал эмнэлгийн гэрчилгээг бичих, баталгаажуулах, хянахад шаардлагатай зарим төхөөрөмжөөр сумын малын эмч, мэргэжилтнүүдийг ханган мал эмнэлгийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эхлүүлэх	Аймаг, сумын төсөв	Жилдээ	МЭГ, сумдын Засаг дарга	8.300.000
11. Мах, сүүнд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээний багажаар хангах	-	Жилдээ	МЭГ, МЭТ	
12. Малчдыг малын эм, биобэлдмэлийг зохистой хэрэглэх арга зүйн талаарх сургалт, мэдээллээр хангаж, хяналт тавих	Аймгийн төсөв	Жилдээ	ХОХБТХ, МЭГ	10.000.000
13. Мал сүрэгт тандалт шинжилгээ хийж, түүний дүнг үндэслэн тухайн бүс нутгийг мал, амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс болохыг баталгаажуулж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх	<b>1.3. Газар тариалангийн салбар</b>			
14. Хүнсний ногооны төрөлжсөн зоорь шинээр барих, сэргээн засварлах	Аймаг сумын төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	Сумын ЗДТГазар	

15.	Өвлийн хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Аймаг сумын төсөв, хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар	3.500.000
16.	Нарийн цувриан тариалангийн талбайн услалтын системийн засвар шинэчлэл хийх	Аймаг, сумын төсөв, хөтөлбөр	Жилдээ	ХОХБТХ, ХХААГ, сумдын Засаг дарга	
17.	Малын тэжээл тариалах аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх	Аймаг, сумын төсөв	3-5 дугаар сар	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар	
18.	Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарын үзүүлэлтийг тогтоох хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатороор хийлгэх	Сумын төсөв	Жилдээ	ХАА-н тасаг	1.500.000
19.	Сумын хэмжээнд тариалангийн болон атаршсан газрын тооллого хийх	Сумын төсөв	6 дугаар сард	ХАА-н тасаг	
<b>1.4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбар</b>					
20.	Хужиртад үйлдвэрлэв стандартын шаардлагад нийцсэн агуулах бүхий худалдааны төвтэй болоход дэмжлэг үзүүлэх	Аймаг сумын төсөв, хөтөлбөр	Жилдээ	Сумын Засаг дарга	25.500.000
21.	Төсөл хөтөлбөрүүд болон хөнгөлөлттэй зээлийн мэдээллүүдийг нэгтгэн олон нийтэд танилцуулах, хамрагдах боломжийг нэмэгдүүлэх	-	Жилдээ	ХАА-н тасаг	
<b>2.Сумдын Засаг дарга нарын хэрэгжүүлэх арга хэмжээ</b>					
22.	Сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг сайжруулан хэрэгжүүлэх	-	Жилдээ	ХАА-н тасаг	
23.	Малчин өрх бүрт өөрийн өмчилж авсан өвөлжөө хаваржааныхаа 0.7 га газарт 0.1 га-аас хэтрүүлэхгүйгээр бэлчээрийн олон наст ургамлын үр цацаж тариалахыг зөвшөөрч, арга зүйгээр хангаж, үрийн дэмжлэг үзүүлэх	Сумын төсөв	Эхний хагас жилд	Аймгийн ХХААГазар, Сумын ХАА-н тасаг	

24.	Зорилтот жилийн хүрээнд сум, баг, иргэдийн нөөц бололцоонд тулгуурлан "Хадлан тэжээл бэдтгэсэн, хороо, бууцаа тохижуулсан байдал зэргийг харгалзан үзэж урамшуулалтай уралдаан зарлаж, дүгнэх	Сумын төсөв	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар	400.000
25.	Шинээр малчин болж байгаа болон амьжиргааны түвшин доогуур малчин өрхийг өвөлжөө, хаваржаа, худаг устай болгох ажлыг зохион байгуулах	Сумын төсөв	Жилдээ	Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг	
26.	Хөдөө аж ахуйд суурилсан брэнд бүтээгдэхүүнтэй болох, орон нутгийнхаа онцлогт тохирсон жижиг, дунд үйлдвэр, цех байгуулахад дэмжлэг үзүүлэх, сургуулийн үдийн цайнд орон нутагт үйлдвэрлэсэн цагаан идээг нийлүүлэх	Сум хөгжүүлэх сан, бусад эх үүсвэр	Жилдээ	Сумдын Засаг дарга	
27.	Бод малд GPS суулган байршлыг хянах ажлыг эрчимжүүлэх, малчдад сурталчилан таниулах	-	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ХАА-н тасаг	
28.	Атаршсан талбайг эргэлтэд оруулж, малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Сумын төсөв, Сум хөгжүүлэх сан, төсөл, хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ХАА-н тасаг	
29.	Сонгино, саримсны тариалалтыг нэмэгдүүлж, орон нутгийн хөрсөнд тохирсон үрийн нөөцтэй болох	Сум хөгжүүлэх сан, төсөл, хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ХАА-н тасаг	
<b>3. Хөдөө аж ахуйн салбарын зөвлөлдөх дэд ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээ</b>					
30.	Суманд жишиг хоршоог хөгжүүлэх, нэг сум, нэг хоршоо хөдөлгөөн өрнүүлэх, малын гаралтай түүхий эдийн анхан шатны тордолт хийх талаар малчид, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдэд шат дараалсан сургалтууд зохион байгуулж, мэдээлэл, зөвлөгөө хүргэх	Сумын төсөв, Төсөл, хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар	
31.	Малчид, тариаланчдад малын тэжээлийн шимт чанар, тэжээл үйлдвэрлэх, мал тэжээх арга туршлагын талаар арга зүй боловсруулан хүргүүлж, мэдээ, мэдээллээр хангах	Аймаг сумын төсөв, төсөл хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг	

**4. Үйлдвэрлэл, хамтын ажиллагаа, хамтын ажиллагаа, цахим мэдээллийн дэд ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээ**

32.	Зорилгот жилийн хүрээнд пэйж хуудас үүсгэн мэдээ, мэдээлэл, сургалт, арга туршлага, зөвлөмж, үйл ажиллагааны талаар баяжуулан хөтөлж, хөгжүүлэх	-	Жилдээ	ХАА-н тасаг	
33.	“Хужиртад үйлдвэрлэв-2021”, Шилмэл малын болон малын тэжээлийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	Сумын төсөв	9 дүгээр сард	Сумын ЗДТГазар, ХАА-н тасаг	2.000.000
34.	Төсөл, хөтөлбөрийн байгууллагуудад санал хүргүүлэх, хамтран ажиллах, санхүүжилт татах ажлыг зохион байгуулах	Аймаг сумын төсөв,	Жилдээ	Сумдын Засаг дарга	
35.	Албан байгууллагууд хүнсний агуулах зоорьтой болоход дэмжлэг үзүүлэх	Аймаг сумын төсөв, хөтөлбөр	Жилдээ	Аймгийн ХХААГазар, Сумын ЗДТГазар,	

--oOo--